



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/210

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2013 оны "Гадаад байгууллагын төлөөлөгч, иргэнтэй харилцах журам" батлах тухай А/153 дугаар захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны "Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичиг батлах тухай" 29, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 07 дугаар тогтоол, 2025 оны "Чингэлтэйн боловсрол-2028" арга хэмжээ батлах тухай 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Бүгд Найрамдах Турк улсын Пендик дүүрэгтэй хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг сайжруулах, гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлийн дагуу сурагч солилцооны хөтөлбөрт хамрагдах багш, сурагчдыг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, сонгон шалгаруулалтын тайланг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (О.Батмөнх)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010619

Дүүргийн Засаг даргын 2025 оны 06
дугаар сарын 10-ны өдрийн 1/210
дүгээр захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

О.Батмөнх

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын
дарга

Гишүүд:

Г.Хурцбаяр

Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга

Л.Баярмаа

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
хөгжлийн хэлтсийн дарга

Т.Батцэцэг

Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
дарга

Д.Ариунболд

Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга

Б.Болортунгалаг

Дүүргийн "Хүүхэд хөгжлийн
цогцолбор" УТҮГ-ын дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Билгүүн

Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн